

## **“Ерөнхий Боловсролын сургуулийн үйл ажиллагааны үнэлгээний аргачлал” төсөл**

### **Төслийг гүйцэтгэх үндэслэл, шаардлага**

Боловсролын хяналт, үнэлгээний үйл ажиллагаа ихэвчлэн багш, сурагчдын үйл ажиллагаа, сурлагын амжилтын үнэлгээнд тулгуурлаж явагддаг бөгөөд энэ нь сургууль, багш нарын үйл ажиллагаанд түлхэц өгөхөөс илүүтэй тухайн шалгалт үзлэгийг “аргалж” өнгөрөөгөөд тайвширч хуучин хэвээрээ ажилладаг хэвшил тогтоход хүргэсэн. Чухам үүний улмаас боловсролын байгууллагад өөрчлөлт, шинэчлэл удааширч байгаад бодит дүгнэлт хийсний үндсэн дээр энэхүү төслийн санаа гарсан юм.

Боловсролын үнэлгээний эцсийн зорилго нь хүмүүсийн ажлыг үнэлж дүгнэхээсээ илүү тухайн байгууллагын иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанарыг үнэлж тэнд байгаа ололт, доголдлын учир шалтгааныг илрүүлэхэд дэм үзүүлэхэд чиглэх ёстой. Өнөөгийн үзлэг шалгалтын ингэж чадахгүй байгаагийн гол шалтгааныг түүний арга зүйтэй холбоотой гэж үзсний үүднээс энэхүү төслийг хэрэгжүүлэхээр шийдэв.

### **Төслийн зориулалт**

Боловсролын байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан бодитой үнэлэх боломжийг бүрдүүлэх, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлэхэд дөхөм үзүүлэх

### **Төслийн зорилго**

ЕБС-ийн үйл ажиллагааг тухайн байгууллагын хамт олны оролцоотойгоор үнэлэх аргачлалыг боловсруулах, турших

### **Төслөөс гарах үр дүн**

Сургалтын байгууллагын үйл ажиллагааг өөрсдийнх нь хамт олны оролцоотойгоор үнэлэх аргачлал боловсруулагдана.

Үнэлгээний бодит байдал, үр ашиг өгөөж дээшилнэ

### **Төслийн үр дүнгийн шинэлэг болоод дэвшилтэт талууд**

1. Боловсролын үнэлгээ нь жинхэнэ үйлчилгээний чанарын үнэлгээ болох эхлэл тавигдана.
2. Сургуулийн үйл ажиллагааг олон нийтийн оролцоотой үнэлэх аргачлалын нэг хувилбар гарна.
3. Хяналт, шалгалтын ажлын тухайн байгууллага, ажилтны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл, үр өгөөжийг дээшлэх анхны алхам хийгдэнэ.